



Бие дааж бодох бодлого

1. Автомашин (1), дугуйчин (2) хоёрын хөдөлгөөний графикийг 7-р зурагт харуулав. Тэдгээр графикийг ашиглан автомашин, дугуйчин хоёрын уулзах хугацаа, уулзах газрыг олцгоо. (1.8 с; 2.10 с; 3.12 с; 4.4 с; 1.150 м; 2.200 м; 3.230 м; 4.75 м).



2. Автомашин хөдөлгөөний тэгшитгэл $X = 60t$ дүрсээр өгөгдөв (X - км-ээр, t - цагаар) Түүний хурдыг тодорхойл.

3. Галт тэрэгний хөдөлгөөний хурдны хууль $X = 240 - 40t$ дүрсээр бичигдэв. Хурдны утгыг тодорхойл. Координат хугацаанаас хамаарах хамаарлын график байгуулаад, уул графикаар гарсан үр дүнг (X - км-ээр, t - цагаар) шалгацгаа.

4. Хоёр автомашин А ба В хотоос өөд өөдөөсөө гарлаа. Нэгдүгээр автомашины хурд 60 км/ц, хоёрдугаарынх 80 км/ц. Хоёрдугаар машин нэгдүгээрээс 1 цагаар хожуу гарав. Хот хоорондын зай 560 км. Тэдгээрийн уулзах хугацаа, газрыг тодорхойл (Нэгдүгээр машин гарснаас хойш 4,57 цаг, А хотоос 274,2 км).

5. Материал цэгийн координатын өөрчлөлтийн графикаар (8-р зур.) хөдөлгөөний хурдыг тодорхойлж, хурдны график байгуулцгаа. Хурдыг км/ц -аар илэрхийл (1.3,6 км/ц; 2.360 км/ц; 3.36 км/ц; 4.36 км/ц).

6. Материал цэгийн хөдөлгөөний тэгшитгэл $X = 20t - 2t^2$ дүрсээр өгөгдөв. Биеийн хурд хугацаанаас хамаарах хамаарлыг илэрхийлсэн томъёог бич. Хурд хугацаанаас хамаарах хамаарлын график байгуулцгаа (1. $v = -4t$; 2. $v = 20 - 4t$; 3. $v = -20 + 4t$; 4. $v = -20 - 4t$).

7. Хэрэв биеийн хурд $v = 6 + 2t$ (СИ) дүрсээр өгөгдсөн бол 10 с-ийн дотор түүний шилжилтийг тооцон бод (1. 16 м; 2. 160 м; 3. 1,6 м; 4. 1600 м).